



МОНГОЛЫН ХҮҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВИЙН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2021 он

ТОВЪЁОГ

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

- 1.1 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжилт 2-7
- 1.2 Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, үр дүн8-11

ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

/Хүүхдийн урлан бүтээх төвийн дүрэм НИТХ-ын 2014 оны 103 дугаар тогтоол/

2.1. Хүүхдийн хүсэл сонирхолд нийцүүлэн авьяасыг нь хөгжүүлж, мэргэжлийн чиг баримжаатай болгож, тодорхой түвшний мэдлэг, ур чадварыг эзэмшүүлнэ зорилтын хүрээнд хийсэн ажил11-13

2.2. Ерөнхий боловсролын сургуулийн анги удирдсан болон мэргэжлийн багш нар, эцэг эх асран хамгаалагчидтай хамтран ажиллаж тэдэнд мэргэжлийн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлнэ зорилтын хүрээнд хийсэн ажил13-15

2.3. Сургалт явуулах орчин бүрдсэн, сургалтын хэрэглэгдхүүн бүрэн анги танхимд сургалт явуулна зорилтын хүрээнд хийсэн ажил15-17.

2.4. Төв нь үндсэн зорилт чиг үүргээ хэрэгжүүлэх асуудлаар өөрийн орны болон гадаад улс орнуудын төрийн болон төрийн бус байгууллага, иргэнтэй хууль тогтоомжийн хүрээнд харилцан хамтарч ажиллана зорилтын хүрээнд хийсэн ажил17-20

2.5. Суралцагчдын мэдлэг, чадвар төлөвшлийг сургалтын явцад анги дэвших, төгсөхөд нь дүгнэх болон сурлагын амжилтын хяналт, үнэлгээ хийх тусгай аргачлалтай байна зорилтын хүрээнд хийсэн ажил20-21

2.6. Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор багш, суралцагчдын хамтарсан, бие даасан бүтээлийн үзэсгэлэн гаргаж, өөрийн оронд болон гадаад улс оронд зохиогдох уралдаан тэмцээнд тогтмол оролцуулна зорилтын хүрээнд хийсэн ажил21-22

ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД

- 3.1.Төсөв, санхүүгийн чиглэлээр.....
- 3.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр.....
- 3.3. Архив, албан хэрэг, хөтлөлтийн чиглэлээр.....
- 3.4.Ил тод байдлын чиглэлээр.....
- 3.5. Хүний нөөцийн чиглэлээр.....
- 3.5.1.Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөөг боловруулж биелэлтийг хангаж ажиллах
- 3.5.2. Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг боловруулж биелэлтийг хангаж ажиллах..... 22-29


ДҮГНЭЛТ..... 30

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

1.1 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх:

1.1.1 “Ковид 19” цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээ хэрэгжүүлэх, Гамшгаас хамгаалах анги, мэргэжлийн анги, нутгийн захиргааны байгууллагуудын салбар хоорондын харилцан ажиллагааг зохион байгуулах, гамшгаас хамгаалах бэлэн байдлыг хангаж, эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогыг хэрэгжүүлнэ.

- Шинэ төрлийн коронавируст халдвар Ковид-19 цар тахлын дэгдэлт, тархалттай холбогдуулан гарсан МУЗГ-ын тогтоол, УОК, НОК, Нийслэлийн Засаг даргын захирамж, шийдвэрүүдийн биелэлтийг хангах ажлын хүрээнд бүх нийтийн бэлэн байдлын болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийн үед ажиллах тусгай төлөвлөгөө боловсруулан гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж гүйцэтгэлийг ханган мэргэжлийн ангийн бие бүрэлдхүүнийг үүрэгжүүлж ажиллаа.








1.1.2. /2.3.1.1/ Багш нарын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх сургалтыг үе шаттай зохион байгуулна.

- Төвийн багш, албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Багш хөгжил шавьд” лекц цуврал сургалтыг 3 удаа, дотоодын цахим сургалт 7 удаа, танхимын сургалт 1 удаа, хамтын ажиллагааны хүрээнд Монголын урлагийн зөвлөл болон бусад эрүүл мэндийн байгууллагатай хамтран мэргэжлийн болон эрүүл мэндийн сургалтуудыг зохион байгуулав. Туршлага солилцох цахим сургалтууд:

- Зураас уу? Зураг уу?” “ногоон алим” уран бүтээлийн тайлбар
- Үзэсгэлэн хэрхэн яаж гаргах тухай
- Урлагаар дамжуулан өөрийгөө хөгжүүлэх нь
- Хар зургийн үндэс уран зургийн тухай
- Байгаль судлал ба судалбар аялал бодит зургийн тухай
- Хуримтлал ба хадгаламж

- Эрүүл зөв хооллолт зэрэг цахим сургалтуудыг зохион байгууллаа.



Урлагаар дамжуулан
өөрийгөө
хөгжүүлэх нь



2021 он

Багш: Д.Ганболд

ҮЗЭСГЭЛЭН

СУРГАЛТ, АРИЛЦЛАГА Б.БАТЦОЖ Д.ГАНБААТАР

МОНГОЛЫН ХҮҮХДИЙН УРЛАН БҮТЭЭХ ТӨВ
ХАР ЗУРГИЙН ҮНДЭС
/ДҮРСИЙН БАЙГУУЛАЛТ, ТАТАЛБАР, ХАРЖ ЗУРАХ/

БАГШ: Ш.БААТАРДАЛАЙ

2021 ОН

Байгаль судлал- Судалбар аялал



МХУБТ-ийн багш Б. Нарангэрэл

Монгол бичгийн үүсэл, хөгжил

МХУБТөвийн Монгол уран бичлэгийн
Дугуйлангийн багш Д.Дуламсүрэн

ЗУРААС УУ? ЗУРАГ УУ?

Монголын хүүхдийн урлан бүтээх төвийн багш:
Н.Мөнхтуул
Т.Даваасамбуу
Б.Ичинхорлоо

БИ ХЭН БЭ?

МХУБТ-ийн багш нар: С.Ганцэцэг
Э.Бямбасүрэн
Б.Ханхай

- “Төрийн албан хаагчийн ёс зүй” сургалт



1.1.3. /2.6.4.1/ Үндэсний агуулга шингэсэн уран бүтээлийг дэмжинэ


- "ӨВ СОЁЛОО ДЭЭДЭЛДЭГ БҮТЭЭЛЧ МОНГОЛ ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ" уриан дор олон улс болон улс Нийслэлийн хүрээнд үндэсний бичиг соёл, өв уламжлалыг хүүхэд багачуудад сурталчлан таниулах олон талт ажлуудыг зохион байгуулна.

- МУ-ын Ерөнхий сайдын ивээл дор “Тусгаар тогтнолын үнэ цэн” уран зураг, гар урлал, уран бичлэгийн үзэсгэлэн уралдаан, Монгол уран бичлэгийн “Мөнх тэнгэрийн бичиг” сурагчдын бүтээлийн үзэсгэлэн, Монгол Улсын Соёлын яамтай хамтран Соёлын Бүтээлч сарын аяны хүрээнд “Монгол туургатны Өв соёл” Олон улсын хүүхдийн уран бүтээлийн наадмыг тус тус зохион байгууллаа.

- Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулдаг “Тусгаар тогтнолын үнэ цэн” уран зураг, гар урлал, технологи, уран бичлэгийн үзэсгэлэн, наадмыг онлайн-аар зохион байгуулж шилдэг бүтээлийн эздийг тодруулж шагнаж урамшууллаа. Шилдгээр шалгарсан сурагчдын төвийн цахим хуудаснаа байршуулж олон нийтэд түгээж ажиллаа.



- Их эзэн Чингис хааны мэндэлсний ой, Монгол бахархлын өдрийг тохиолдуулан “Мөнх тэнгэрийн бичиг” үзэсгэлэн 10 дах жилдээ зарлагдаж уралдааны бүтээлүүдээ хүлээн авч байна. Үзэсгэлэн Уран бүтээлчид, ЕБС-ийн багш нар, ЕБС-ын 8-12дугаар ангийн сурагчид гэсэн 3 ангилалаар явагдаж одоогоор нийт 300 гаруй бүтээл ирсэн.



- Монгол Улсын Соёлын яамтай хамтран Соёлын Бүтээлч сарын аяны хүрээнд “Монгол туургатны Өв соёл” Олон улсын хүүхдийн уран бүтээлийн наадмыг Монгол туургатны түүх, өв соёл, зан заншлыг түгээн дэлгэрүүлэх, тэдний бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор Дүрслэх урлаг, Гар урлал, Монгол уран бичлэгийн төрлөөр зохион байгууллаа.

Тус уралдаанд ОХ-ны БНБУлс, БНХУлс, БНТУлс, БНХАУ-ын ӨМӨЗО, АНУ-уудаас 223, Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудаас 349, Архангай Өвөрхангай, Дорнод, Завхан, Увс, Хөвсгөл, Ховд, Дархан-Уул, Сэлэнгэ, Дундговь, Дорноговь аймгуудаас 38 хүүхэд багачууд нийт 610 бүтээлээ ирүүлж оролцсон.

“Монгол туургатны Өв соёл” үзэсгэлэнгийн нээлт, шагнал гардуулах ёслолын ажиллагаанд Монгол Улсын Соёлын яамны Соёл Гэгээрлийн газрын дарга Д.Наранцэцэг, Монголын Хүүхдийн Урлан Бүтээх Төвийн захирал Д.Уранбилэг нар шилдгээр шалгарсан хүүхэд багачуудыг шагнаж урамшууллаа.





- Байгууллагаараа “Монгол бичигтэн” болох хөдөлгөөн өрнүүлж 7 хоног бүрийн 5 дах өдөр буюу Баасан гаригт нийт албан хаагчид Монгол бичгийн дугуйланд суралцаж өөрсдийн мэдлэг боловсролоо дээшлүүлж байна.



1.2 ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

Бид үйл ажиллагаандаа удирдах дээд шатны байгууллагаас ирүүлсэн тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ	Шалтгаан
1	2	3	4	5	6
			Салбар чиглэл: 1		
1.а. Засгийн газрын тогтоол					
57	4.4	ЗГ-ын 57-р тогтоол	Байгууллага хоорондын гэрээ байгуулах журмын хэрэгжилтийг ханган ажилласан.	100%	
206, 216-218,	1,1, 1	МУЗГ-ын 2020.206-р тогтоол, 216-218-р тогтоол	Байгууллагын ажилтан албан хаагчдаар 4 модуль хичээлийг судлуулж НЗДТГ-ын хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст 2021.04.30-нд илгээн ажилласан.	100%	
01, 4		2021.05.11 01-р тогтоол, ЗГ-ын 2018.01.03-ны өдрийн 4-р тогтоол	Байгууллагын дэргэдэх залуучуудын зөвлөлийг байгуулж мэдээллийг 2021.05.24-ний өдөр албан бичгээр илгээсэн.	100%	
178		МУЗГ-ын 2021.06.30-ны өдрийн 178-р тогтоол	2020 оны гүйцэтгэл, 2022 оны төсвийн төсөл, 2023-2024 оны төсвийн төсөөлөл 2021.07.21-ний өдөр НЗДТГ-т албан бичгийн хамт илгээсэн.	100%	
160	1	ЗГ-ын 2021.06.01-ний 160-р тогтоол	Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмыг байгууллагын үйл ажиллагаанд мөрдлөг болгон ажилласан.	100%	
33	1	ЗГ-ын 2019. 33-р тогтоол	Төрийн албаны ёс зүй хэм хэмжээг мөрдүүлэх хэрэгжилтийг ханган ажилласан	100%	
15	7.5.1	ЗГ-ын 2021 оны 15-р тогтоол, НЗД-ын 2021 оны А/846-р захирамж	Манай байгууллага нь цахим тооллогод хамрагдсан бөгөөд уг аяныг олон нийтэд хүргэх ажлыг дэмжин ажилласан.	100%	
118, 259	7.1.1	ЗГ-ын 2021 оны 118, 259-р тогтоол	Коронавируст халдвар /Ковид-19/-ын эсрэг дархлаажуулалтыг эрүүл мэндийн байгууллагаас гаргасан зөвлөмжийн дагуу дархлаа сэргээх нэмэлт тунд төрийн албан хаагчдын манлайлал оролцоог нэмэгдүүлж албан хаагчдаа дархлаажуулалтад идэвхтэй хамруулж ажилласан.	100%	

299	29.3.1	ЗГ-ын 2019 оны 299-р тогтоол	Байгууллагын албан хаагчдыг судалгаанд хамруулж ажиллав.	100%	
315	1	ЗГ-ын 2021 оны 315-р тогтоол НЗД-ын 2021 оны А/846-р захирамж	Байгууллагын дэргэдэх бүх өмчийн хэлбэрийн тооллогод бүрэн хамрагдаж албан бичгийн хамт илгээж хүргүүлэн ажилласан.	100%	
1.б. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол					
55		НИТХ-ын тэргүүлэгчдийн 55-р тогтоол	Өмч эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулсан.	100%	
65	1	НИТХ-ийн тэргүүлэгчдийн 2014 оны 65-р тогтоол	Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний биелэлтэд түрээслүүлэгч хяналт тавих заасан хугацаанд баримт бичгийг хүргүүлж ажилласан	100%	
1.в. Нийслэлийн Засаг Даргын Захирамж					
779		НЗДТГ-ын 2021.10.12-ны А/779-р захирамж	Хуваарилагдсан хорооны албан хаагчидтай хамтран мэдээ тайланг цаг тухай бүрт гарган хүргүүлж захирамжийн хэрэгжилтийг ханган ажилласан.	100%	-
586		НЗД-ын 2021 оны А/586 захирамж	Манай байгууллагад газартай холбоотой зөрчил маргаан байхгүй болно.	100%	
1054	29.2	НЗД-ын 2019 оны А/1054-р захирамж	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын Uber системийг нэгдсэн журмаар өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна.	100%	
929		НЗД-ын 2021 оны А/929-р захирамж	Ер системээр хариуг Үйлчилгээний шийдвэрлэлтийн хяналт хариуцсан ажилтан Б. Мандухайд Эдийн засгийн сэргэлтийг эрчимжүүлж цар тахлын үед эдийн засагт үзүүлж буй нөлөөг бууруулах судалгааг илгээсэн болно.	100%	
933		НЗД-ын 2021.11.29-ны А/933-р захирамж	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын спортын 4-р арга хэмжээнд 3 төрлөөр оролцсон.	100%	
241	13.1	Хууль зүй дотоод	Байгууллагын архивын нэгдсэн тоо бүртгэлийг 2020 оны байдлаар албан	100%	

		хэргийн сайдын 2020 оны А/241 тушаал	бичгийн хамт 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдөр НАГ-т илгээж ажилласан.		
302		НЗД-ын 2021 оны А/302 захирамж	Хотын соёл аяны төлөвлөгөө тайланг боловсруулж Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Соёл урлагийн газарт хүргүүлж ажиллаа.	100%	
1086		НЗД-ын 2013 оны А/1086-р захирамж	УВ егр системд бүртгэж холбогдох албан тушаалтанд шилжүүлэн хяналт тавьж хуулийн дагуу заавар журмыг биелүүлэн ажилласан.	100%	
1.г. Нийслэлийн Онцгой Комиссоос гаргасан шийдвэрийн биелэлт					
		НОК	Түр зааварчилгааг нийт багш, албан хаагчдад танилцуулж, үйл ажиллагаандаа тусган ажилласан.	100%	
27		НОК-ын 27-р хурлын тэмдэглэл	Хуралдаануудын тэмдэглэлтэй танилцаж, зөвлөмжийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%	
		НОК-ын 2021.10.15-ны өдрийн хурлын тэмдэглэл	Манай байгууллага нийт 49 хүнээс 1 тунтай 2 хүн, 2 тунтай 42 хүн, 3 тунтай 3 хүн, Сайн дураараа хийлгээгүй 2 хүн Ковидын халдвар авсан 27 хүн байна. Нийслэлийн Онцгой Комиссын 2021 оны 10 дугаар сарын 19 №673 тоот албан бичгийн дагуу байгууллагын албан хаагчдаа Коронавируст /Ковид-19/ халдвараас урьдчилан сэргийлэх нэмэлт дархлаажуулалтад хамрагдахыг эрчимжүүлэн мэдээлэл өгөн ажиллаж байна.	100%	
		НОК-ын 2021.11.04-ний өдрийн албан бичиг	Улсын онцгой комиссын нэгдсэн шуурхай штабаас 2021 оны 11 дүгээр 04-ний өдрийн 10685 дугаартай албан бичгээр Коронавируст халдвар /Ковид/ -ын эсрэг дархлаажуулалтын 3 дугаар тунгийн хамрагдалтыг нэмэгдүүлэх чиглэлийн дагуу дархлаа сэргээх нэмэлт вакцинжуулалтад хамруулсан мэдээллийг өдөр бүрийн 17:00 цагт сүүлийн 24 цагаар болон өссөн хувь хэмжээгээр гарган Ulam.naraa2404@2404gmail.com хаягаар мэдээ явуулан ажилласан.	100%	
18		НОК-ын 18-р хурлын тэмдэглэл	Байгууллагынхаа албан хаагчдын дархлаажуулалтын нэмэлт тунд хамруулан ажиллаж хамрагдалтын тайланг nokshuurhaishtabgmail.com цахим хаягаар илгээж ажилласан.	100%	

20		НОК-ын 20-р хурлын тэмдэглэл	Дархлаажуулалтын цэгийг нэмсэнтэй холбогдуулж ойр байрлах цэгт байгууллагынхаа албан хаагчдыг ажлын нэг өдрийн чөлөө олгож, дархлаажуулалтын нэмэлт тунд хамруулах ажлыг зохион байгуулан ажиллаж 49 хүнээс 1 тунтай 2 хүн, 2 тунтай 12 хүн , 3 тунтай 33 хүн	100%	
11		НОК-ын 11-р хурлын тэмдэглэл	Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас Өмнөд Африкаас гаралтай шинэ хувилбарт Омикрон вирус дахин халдварлуулах эрсдэл өндөр байгааг анхааруулсантай холбогдуулан албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, бэлэн байдлыг хангах хариу арга хэмжээг аван анги танхим өрөө тасалгаанд халдваргүйтгэл хийлгэж, маск байнга зүүх, өдөр бүр халуун үзэж тэмдэглэх гараа байнга угаахыг сануулан ажлыг зохион байгуулан ажиллаж байна.	100%	

ХОЁР. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

/ Хүүхдийн урлан бүтээх төвийн дүрэм НИТХ-ын 2014 оны 103 дугаар тогтоол/

2.1. Хүүхдийн хүсэл сонирхолд нийцүүлэн авьяасыг нь хөгжүүлж, мэргэжлийн чиг баримжаатай болгож, тодорхой түвшний мэдлэг, ур чадварыг эзэмшүүлнэ”

2.1.1 2021-2022 оны хичээлийн жилд дүрслэх урлаг, гар урлал, техник технологийн чиглэлээр хүүхэд багачуудын авьяас чадвар, бүтээлч сэтгэхүйг хөгжүүлж, амьдралын арга ухаанд сургаж, хөдөлмөр гоо зүйн хүмүүжил, мэргэжлийн чиг баримжаа олгоно.

- 2021-2022 оны хичээлийн жилд 19 төрлийн 22 дугуйланд 1200 хүүхэд багачууд хичээллэж байна. Цар тахлын нөхцөл байдлын улмаас анги танхимын дүүргэлт 50%-д хичээллэж байгаа болно.



2.1.2 Хүүхдийн хөгжлийг дэмжсэн соёлын олон талт арга хэмжээг зохион байгуулж, хүүхэд багачуудыг идэвхтэй хамруулна.

- Монгол хүн сансарт ниссэний 40 жилийн ойн олон улсын үзэсгэлэнд нисэх загварын дугуйлангийн сурагчид, Зүүн Хойд Бүс нутгийн засаг захиргаа NEAR-ын холбооноос 8 дах удаагаа зохион байгуулсан гар зургийн уралдаанд 7 сурагч оролцсон.



- Монгол улсад хууль зүйн алба үүсэн байгуулагдсаны 110, орчин цагийн цагдаагийн байгууллага байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд "БИДНИЙ БААТАР ЦАГДАА" уран зургийн уралдааныг Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэстэй хамтран зохион байгуулж ажиллаа.

БИДНИЙ БААТАР ЦАГДАА уран зургийн уралдаанд хөдөө орон нутаг, нийслэлээс нийт 646 авьяаслаг уран бүтээлч хүүхдүүд бүтээлээ ирүүлсэн байна.




- Уушгины хатгалгаатай тэмцэх дэлхийн өдрийг тохиолдуулан Монгол Улсын үнэт ирээдүй болсон хүүхэд багачуудаа хамгаалах, эрүүл аюулгүй орчинд өсгөх, сурган хүмүүжүүлэх, баяр хөөртэй амар амгалан байлгах, чөлөөт цагийг нь зөв зохистой бүтээлчээр өнгөрүүлэх зорилгоор дүрслэх урлагаар дамжуулан хүүхэд багачуудыг уушгины хатгалгаа өвчнөөс сэргийлэх, хүүхдийн өвчлөлийг бууруулахад эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хүүхдийн бүтээлч сэтгэлгээ, ур чадвар, танин мэдэхүйг хөгжүүлэх, оюуны бүтээлийг дэмжих хөгжүүлэхээр Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвтэй хамтран "Цэвэр агаар-Эрүүл уушги" зургийн уралдааныг зохион байгуулав.

2.2. Ерөнхий боловсролын сургуулийн анги удирдсан болон мэргэжлийн багш нар, эцэг эх асран хамгаалагчидтай хамтран ажиллаж тэдэнд мэргэжлийн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлнэ”

2.2.1 Олон улсын наадам, үзэсгэлэн, уралдаанд багш нарыг идэвхтэй хамруулах хүрээнд төвийн багш нарт олон улсын 8 уралдааны зар мэдээллүүдийг хүргэж ажиллаа.

2.2.2 “Хамтдаа хөгжье ” Эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх нээлттэй өдөрлөг зохион байгуулна.

- Нийслэл хот байгуулагсаны 382 жилийн ойн хүрээнд “Хамтдаа хөгжье” эцэг эх, олон нийтийн нээлттэй өдөрлөгийг 3 удаа зохион байгууллаа. Өдөрлөгийн үйл ажиллагаанд Ковидын нөхцөл байдлаас хамаарч өдөрлөг тус бүрт 50 эцэг эх оролцож өөрсдийн сонирхсон дугуйлангийн хичээлд хүүхэдтэйгээ сууж суралцах боломжоор хангагдаж үйл ажиллагаатай танилцлаа.



- Мөн эцэг, эх асран хамгаалагч нарт зориулсан цахим сургалт, хичээлийг 2 удаа зохион байгуулж ажиллаа.




- Хүүхэд хамгааллын хөтөлбөрийн хүрээнд төвийн дугуйлангийн сурагчдыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Монголын хүүхдийн урлан бүтээх төвийн дугуйлангийн сурагчдыг угтах үдэх үйлчилгээний журам шинээр баталж 10 хүртэлх насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх, багш, эцэг эх, асран хамгаалагчдыг бага насны хүүхдээ “Гараас гарт” хүлээлгэн өгч ажиллах талаар анхааруулсан санамж бичиг үйлдэн хамтран ажиллаж байна.

- Дугуйлангийн сурагчдын дэг журам, аюулгүй байдлыг хангах үүднээс “Монголын хүүхдийн урлан бүтээх төвд хүүхэд суралцуулах гэрээ”-г боловсруулж эцэг, эх асран хамгаалагч нартай гурвалсан гэрээ байгуулан ажиллаа.


2.3. Сургалт явуулах орчин бүрдсэн, сургалтын хэрэглэгдхүүн бүрэн анги танхимд сургалт явуулна.

2.3.1. “Хүүхдэд ээлтэй Урлан” аяныг үргэлжлүүлж, хүүхэд багачуудын эрүүл, аюулгүй орчинд сурч боловсрох таатай нөхцлийг бүрдүүлнэ.

- “Цахим Урлан” аяныг өрнүүлэн хүүхэд, багачуудыг гэр бүлээрээ хамтдаа сурах хөгжих боломжийг бүрдүүлэх, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор видео хичээлийн контентийг санаачлан 75 видео хичээл бэлтгэн өөрийн байгууллагын цахим хуудсанд байршуулж олон нийтэд хүргэж ажиллаж байна. Видео хичээлүүдийн хандалт 45-50 мянган хүний хандалттай.



- Мөн тус аяны хүрээнд Монголын Хүүхдийн Урлан бүтээх төвийн дугуйланд олон жил суралцсан шилдэг тэргүүний хүүхэд багачуудыг алдаршуулах, олон нийтэд таниулах ажлыг өөрийн байгууллагын цахим хуудсаар дамжуулан зохион байгуулж ажиллаа. 40,000 хүний хандалттай.



2.3.2. Хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, хүүхдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, болзошгүй аюул ослоос хамгаалах зорилгоор холбогдох мэргэжлийн хүмүүсээр сургалт зохион байгуулна.

- Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангасан хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлэх, хүүхдүүд болон явган зорчигчийг аюулгүй гарцаар гарах анхааруулгыг төвийн орчимд байршуулан ажиллаж байна.



- Өсвөр үеийнхэнд зориулсан эрүүл мэндийн боловсрол эрүүл амьдралын хэв маягт сургах сургалтын төлөвлөгөө боловсруулан гүйцэтгэлийг ханган ажиллаж байна.

- Шинэ төрлийн КОРОНА вирусын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах зорилгоор Хүүхдийн Урлан Бүтээх Төвийн сургалт зохион байгуулах “Түр журам”, “Сургалтын үед суралцагчдын баримтлах дэг” зэргийг боловсруулан мөрдөн ажиллаж байна.



2.4. Төв нь үндсэн зорилт чиг үүргээ хэрэгжүүлэх асуудлаар өөрийн орны болон гадаад улс орнуудын төрийн болон төрийн бус байгууллага, иргэнтэй хууль тогтоомжийн хүрээнд харилцан хамтарч ажиллана.

2.4.1 Монгол Улсад суугаа Элчин сайдын яамдуудтай хамтран Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчид, халамж, асрамжийн газрын болон зорилтот бүлгийн хүүхдүүдийн уран бүтээлийн үзэсгэлэн, уралдааныг зохион байгуулна.

- БНЭУ-аас МУ-д суугаа ЭСЯ-тай хамтран Энэтхэг улс, Монгол улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 65 жилийн ойн хүрээнд хүүхдийн гар урлал, уран зургийн уралдааныг цахим хэлбээр зохион байгуулж оролцогч хүүхдүүдийн бүтээлийг төвийн цахим хуудаснаа байршуулан шилдгүүдээ шалгаруулсан.

Үзэсгэлэн бага нас “Энэтхэг орон миний нүдээр” бага дунд нас “Миний мөрөөдлийн Энэтхэг орон” дунд нас “Монгол, Энэтхэг улсын оюун санааны нөхөрлөл” ахлах нас “Энэтхэг Монгол улсын эдийн засгийн түншлэл” сэдвээр явагдсан бөгөөд Нийслэл болон хөдөө орон нутгаас 600 гаруй авьяаслаг хүүхдүүд гар урлал, уран зургийн бүтээлээр цахимаар оролцлоо.



- Солонгосын соёлын өдрүүдийг тохиолдуулан БНСУ-аас Монгол улсад суугаа элчин сайдын нэрэмжит 7 дахь удаагийн "МОНГОЛ СОЛОНГОСЫН ӨВ СОЁЛЫН ГАЙХАМШИГ" хүүхдийн уран зураг, гар урлалын үзэсгэлэнгийн нээлтийн арга хэмжээ 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдөр Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн “Орд” арт галерейд боллоо.

Үзэсгэлэнд 569 хүүхдийн бүтээл ирснээс ахлах, дунд, бага насны ангиллаар уран зураг, гар урлал гэсэн 2 төрлөөр шалгаруулж шилдэг бүтээлийг тодрууллаа. Үзэсгэлэнд Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиуд болон Архангай Өвөрхангай, Дорнод, Завхан, Увс, Хөвсгөл, Дархан-Уул, Сэлэнгэ, Өмнөговь,

Баян-Өлгий, Орхон, Говь-Сүмбэр, Дорноговь аймагаас хүүхдүүд идэвхтэй оролцлоо.



- Мөн Монголын дауны холбоо, 70 дугаар тусгай сургууль, Реалист уран бүтээлчдийн НҮТББ, Онцгой авьяастан төслийн багтай хамтран тусгай хэрэгцээт хүүхдүүдийн “Онцгой авьяастан” уран зургийн үзэсгэлэнг зохион байгууллаа.
- 2.4.2 Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран соёлын олон талт арга хэмжээг санаачлан зохион байгуулж, төвийн үйл ажиллагааг сурталчлан өргөжүүлнэ.
- Юнайтед Бродкастинг Корпорэйшн ХХК-ны “Стар ТВ” телевизтэй хамтран “Хамтдаа сурья” хүүхдийн нэвтрүүлгийн контент 70 дугаарыг дугуйлангийн багш, сурагчдыг оролцуулан бэлтгэж олон нийтэд хүргэн ажиллаж байна.

БАГАВ:
“ЮНАЙТЕД БРОДКАСТИНГ КОРПОРАЙШН” ХХК
ГҮВЭЙГЭЭ ХУВААГА
БАДААМАН

БАГАВ:
“МОНГОЛЫН ХУУДИЙН УРАН
БҮТЭЭХ ТӨВ”
ЭМБЕДИЙН ХӨДӨЙ
ДЭГЭЭРИЙН ХӨДӨЙ

ХАМТРАН АЖИЛААХ ГЭРЭЭ
2021 оны 09 дугаар сарын 11

НЭГ ШИЙДЭГЧИЙН ҮНДЭСЛЭЛ
1.1 Энэ урилгаар Монголын хуудсийн уран бүтээлчид нь “ЮНАЙТЕД БРОДКАСТИНГ КОРПОРАЙШН” ХХК-ийн “Стар ТВ”-ийн “Хамтдаа сурья” нэвтрүүлгийн үйлчилгээнд оролцох боломжтой болохыг заруулах зорилготой. Энэ урилгаар Монголын хуудсийн уран бүтээлчид нь “ЮНАЙТЕД БРОДКАСТИНГ КОРПОРАЙШН” ХХК-ийн “Стар ТВ”-ийн “Хамтдаа сурья” нэвтрүүлгийн үйлчилгээнд оролцох боломжтой болохыг заруулах зорилготой. Энэ урилгаар Монголын хуудсийн уран бүтээлчид нь “ЮНАЙТЕД БРОДКАСТИНГ КОРПОРАЙШН” ХХК-ийн “Стар ТВ”-ийн “Хамтдаа сурья” нэвтрүүлгийн үйлчилгээнд оролцох боломжтой болохыг заруулах зорилготой.

дугуйлан үйл ажиллагааг зохион байгуулах зорилготой. Энэ урилгаар Монголын хуудсийн уран бүтээлчид нь “ЮНАЙТЕД БРОДКАСТИНГ КОРПОРАЙШН” ХХК-ийн “Стар ТВ”-ийн “Хамтдаа сурья” нэвтрүүлгийн үйлчилгээнд оролцох боломжтой болохыг заруулах зорилготой.

ГЭРЭЭ 1. ХАМТРАН АЖИЛААХ ГЭРЭЭ
1.1 Энэ урилгаар Монголын хуудсийн уран бүтээлчид нь “ЮНАЙТЕД БРОДКАСТИНГ КОРПОРАЙШН” ХХК-ийн “Стар ТВ”-ийн “Хамтдаа сурья” нэвтрүүлгийн үйлчилгээнд оролцох боломжтой болохыг заруулах зорилготой. Энэ урилгаар Монголын хуудсийн уран бүтээлчид нь “ЮНАЙТЕД БРОДКАСТИНГ КОРПОРАЙШН” ХХК-ийн “Стар ТВ”-ийн “Хамтдаа сурья” нэвтрүүлгийн үйлчилгээнд оролцох боломжтой болохыг заруулах зорилготой.

ГЭРЭЭ 2. ХАМТРАН АЖИЛААХ ГЭРЭЭ
2.1 Энэ урилгаар Монголын хуудсийн уран бүтээлчид нь “ЮНАЙТЕД БРОДКАСТИНГ КОРПОРАЙШН” ХХК-ийн “Стар ТВ”-ийн “Хамтдаа сурья” нэвтрүүлгийн үйлчилгээнд оролцох боломжтой болохыг заруулах зорилготой. Энэ урилгаар Монголын хуудсийн уран бүтээлчид нь “ЮНАЙТЕД БРОДКАСТИНГ КОРПОРАЙШН” ХХК-ийн “Стар ТВ”-ийн “Хамтдаа сурья” нэвтрүүлгийн үйлчилгээнд оролцох боломжтой болохыг заруулах зорилготой.

ТӨЛӨӨ ГЭРЭЭНИЙН ӨРХ, ҮҮРЭГ
1.1 Энэ урилгаар Монголын хуудсийн уран бүтээлчид нь “ЮНАЙТЕД БРОДКАСТИНГ КОРПОРАЙШН” ХХК-ийн “Стар ТВ”-ийн “Хамтдаа сурья” нэвтрүүлгийн үйлчилгээнд оролцох боломжтой болохыг заруулах зорилготой. Энэ урилгаар Монголын хуудсийн уран бүтээлчид нь “ЮНАЙТЕД БРОДКАСТИНГ КОРПОРАЙШН” ХХК-ийн “Стар ТВ”-ийн “Хамтдаа сурья” нэвтрүүлгийн үйлчилгээнд оролцох боломжтой болохыг заруулах зорилготой.

ДЭМБ ДАВГААГИЙН ХУМШИГ ГЭЛ
7.1 Энэ урилгаар Монголын хуудсийн уран бүтээлчид нь “ЮНАЙТЕД БРОДКАСТИНГ КОРПОРАЙШН” ХХК-ийн “Стар ТВ”-ийн “Хамтдаа сурья” нэвтрүүлгийн үйлчилгээнд оролцох боломжтой болохыг заруулах зорилготой. Энэ урилгаар Монголын хуудсийн уран бүтээлчид нь “ЮНАЙТЕД БРОДКАСТИНГ КОРПОРАЙШН” ХХК-ийн “Стар ТВ”-ийн “Хамтдаа сурья” нэвтрүүлгийн үйлчилгээнд оролцох боломжтой болохыг заруулах зорилготой.

Багш, сурагчид доорхи хуваарийн дагуу нэвтрүүлгийн бичлэгт орж ажиллаж байна.

"Хамтад суръя-2" нэвтрүүлгийн зураг авалтын төлөвлөлт

№	Бичлэгчдийн нэр	Дураглалын нэр	Утас	Урлан Бүтээх төвд зохион байгуулагдсан үзэсгэлэн													
				18.08	19.08	20.08	21.08	22.08	23.08	24.08	25.08	26.08	27.08	28.08	29.08		
1	Ш.Баатардалай	Уран зураг	9800810														
2	Б.Нарангэрэл	Уран гэрээний ажил	9114881														
3	Н.Баатарцог	Чамалтай уран зураг	9117892														
4	С.Оюунсайхан	Хүүхдийн багш	9828822														
5	А.Төрхөнд	Хүүхдийн багш	9972424														
6	Б.Вуултуул	Хүүхдийн багш	61603000														
7	Н.Дундговь	Гэр урсгалын ажил	6867880														
8	Б.Нэнгэдорно	Ариун уран зураг	9957879														
9	Т.Давьдсавбуу	Уран баримал	9811852														
10	Э.Бямбацэрэн	Арсан урлан	9938600														
11	Р.Энхбаяр	Суртал ажил															
12	Г.Тува	Суртал сулмарал	6423933														
13	Б.Нарангуулагач	Суртал сулмарал	8031099														
14	С.Ганцай	Хүүхдийн урлан	9495073														
15	Д.Ганбатар	Монгол уран баримал	9918806														
16	Д.Далхаасурал	Монгол уран баримал	8855616														
17	Г.Гаралмаа	Монгол урлаг	0171163														
18	Б.Хангай	Баримал ажил	8815499														
19	Д.Ганболд	Уран зураг	99688079														
20	Н.Мөнхтүвшин	Монгол уран зураг	99153451														
21	Г.Газар	Уран баримал	80222180														
22	М.Энхбаяр	Уран зураг	98742966														

- Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвд зохион байгуулагдсан үзэсгэлэн, уралдаан, олон нийтийн арга хэмжээг тогтмол хэвлэл мэдээллийн байгууллагуудаар сурталчлан, олон нийтийн хүртээл болгож байна.

Тухайлбал, МҮОНРТ, Монгол HD, Eagle TV, TV9, SBN, LIKE TV, STAR TV, GTV, VTV, ETV, SCN TV, Үндэсний шуудан, Нийслэл сайт, Read.mn, Монголын радио, Монголын мэдээ сонин, Өдрийн сонин зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай тогтмол хамтран ажиллаж байна.

- Монголын Эмнести Интернэшнл, “Шогч бийр” холбоотой хамтран “Хүний эрх, эрх чөлөө” шог зургийн үзэсгэлэн зохион байгуулж ажиллаа.



2.5. Суралцагчдын мэдлэг, чадвар төлөвшлийг сургалтын явцад анги дэвших, төгсөхөд нь дүгнэх болон сурлагын амжилтын хяналт, үнэлгээ хийх тусгай аргачлалтай байна.

- Төвийн дугуйлангийн сурагчдаас эрдэм мэдлэг, сурлага, урлаг, спортын болон бусад төрлөөр амжилт гарган бусдыгаа манлайлсан хүүхэд багачуудаас “Дүүргийн шилдэг хүүхэд” шалгаруулах үйл ажиллагаанд Д.Ганболд багштай уран зургийн дугуйлангийн сурагч Э.Билгүүнийг тодорхойлж Сүхбаатар дүүргийн 2021 оны “Шилдэг хүүхэд”- ээр тодорлоо.



2.6. Байгууллагын үйл ажиллагааг сурталчлах зорилгоор багш, суралцагчдын хамтарсан, бие даасан бүтээлийн үзэсгэлэн гаргаж, өөрийн оронд болон гадаад улс оронд зохиогдох уралдаан тэмцээнд тогтмол оролцуулна.

2.6.1 Олон улсын наадам, үзэсгэлэн, уралдаанд багш, сурагчдыг дэмжиж идэвхитэй оролцуулна.

- Тус төвийн Уран зургийн багш Ш.Баатардалай Б.Нарангэрэл нар хамтран “ЭТЮД” байгалийн судалбар зургийн үзэсгэлэнг МХУБТөвийн “ОРД” арт галлерейд амжилттай зохион байгууллаа.



- Уран баримлын багш Т.Даваасамбуу “Да Дун” 26 дахь олон улсын дүрслэх урлагын үзэсгэлэн Тайчун хот, Тайван улс, “19th Asian Art Biennale Bangladesh 2021” олон улсын дүрслэх урлагын үзэсгэлэн Бангладеш улс, “Ардын хувьсгалын 100 жил” үзэсгэлэн Монголын Урчуудийн Эвлэлийн үзэсгэлэнгийн танхим, “Толбот саарал” Уран бүтээлийн бие даасан үзэсгэлэн Сэнгэраги Арт галлерейд өөрийн бие даасан үзэсгэлэнгээ гаргахад дэмжлэг үзүүлж хамтарч ажиллаа.



- Монгол зургийн багш Н.Мөнхтуул МУЭХорооноос зохион байгуулдаг “Эмэгтэй уран бүтээлчдийн үзэсгэлэн”, МУЭХорооны дэргэдэх Залуу уран бүтээлчдийн нэгдэлээс зохион байгуулдаг “Алтан бийр 15” цахим үзэсгэлэн, Монголын арьсан урлагийн “Хүрэл буга” нийгэмлэгийн “Шувуучлахуй үзэсгэлэнгүүдэд оролцож, “Zanabazar international art Festival 2021 Mongolia” оролцон чимэглэх урлагийн төрөлд түрүүлсэн амжилтыг үзүүлсэн.



ГУРАВ. ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД:

3.1.Төсөв, санхүүгийн чиглэлээр

- 2021 оны жилийн эцсийн байдлаар нийт 1011990,7 сая төгрөгний санхүүжилтээс 713778,5 сая төгрөгийн гүйцэтгэлтэйгээр аудитаас зөрчилгүй санал дүгнэлтийг авч өглөг авлагагүй ажиллаж байна. ЗГ-ын 64 дүгээр тогтоолын биелэлтийг хангаж төсвийг 12 дугаар сарын 15-ны байдлаар 239.361.935 төгрөгөөр хэмнэж ажиллаа. Үлдэгдэл 298212,2 сая төгрөгийг санхүү төрийн санд төвлөрүүлж ажиллаа. Хуулиар тогтоосон хугацаанд <https://shilendans.gov.mn/org/4315> сайтад мэдээллийг тогтмол байршуулж мөн <http://huuhdiinurlan.ub.gov.mn/> сайт, “Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв” Фэйсбүүк пейж болон мэдээллийн самбарт тогтмол мэдээллүүдийг шинэчлэн байршуулж, үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүүгийн ил тод байдлыг ханган ажиллаж байна.

3.1.2.Үндсэн хөрөнгө бүртгэл, дэд системийн ашиглалтыг бүрэн хариуцаж ажиллах

- Ашиглалтыг сайжруулан ажиллаж байна.

3.1.3 Батлагдсан төсвийн хүрээнд гурвалсан гэрээний үүргээр болон заалны түрээсийн орлогоор төсөвт 12 сая 300 мянган төгрөгний орлого төвлөрүүлэхээс 5717,1 сая төгрөгний орлого оруулсан.

3.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:

3.2.1 Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийх

3.3. Архив, албан хэрэг, хөтлөлтийн чиглэлээр:

3.3.1. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаа нэгдсэн удирдлагаар хангаж, “UB.ERP” системийн Edoc, Өргөдөл гомдол, Тайлан судалгаа, дэд системүүдийн ашиглалтыг бүрэн хангаж ажиллах

- Албан хэрэг хөтлөлтийн www.edoc.ulaanbaatar.mn цахим хуудсыг тогтмол ашиглаж, хариутай албан бичгийг хугацаанд нь шийдвэрлэж ажиллаа.

- Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн захиргааны 12 албан хаагч www.edoc.ulaanbaatar.mn программыг ашиглаж, 50 багш, албан хаагчид www.erp.ulaanbaatar.mn программыг ашиглаж түүний хэрэгжилтэд хүний нөөцийн асуудал хариуцсан мргэжилтэн хяналт тавин ажиллаж байна.

2021 оны байдлаар:


	Албан бичиг	Нийт тоо	Үүнээс:	Шийдвэрлэлт
1	Ирсэн бичиг	139	58 хариутай	98.62%
			81 хариугүй	
2	Явсан бичиг	101	101 хариугүй	100%

3.3.2.Архивын үйл ажиллагааг хууль, дүрэм, зааврын дагуу хөтлөн явуулах

- Захирлын А, Б тушаалуудыг нөхөн бүрдүүлэлтээр цахим хуудаст оруулж, байгууллагын архивын ажлыг заавар, журмын дагуу зохион байгуулан ажиллаж байна.

3.4.Ил тод байдлын чиглэлээр:

- Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төвийн үйл ажиллагааг иргэдэд ил тод, нээлттэй байлгах хүрээнд <http://huuhdiinurlan.ub.gov.mn/> сайт, “Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв” Фэйсбүүк хуудсыг идэвхтэй байлгаж, байгууллагын мэдээллийн самбран мэдээллүүдийг тогтмол шинэчлэн байршуулж ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийг хангаж ажиллаж байна.



3.5. Хүний нөөцийн чиглэлээр:


3.5.1.Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх сургалтын төлөвлөгөөг боловруулж биелэлтийг хангаж ажиллах


- Хөтөлбөрийн хүрээнд “Стандартыг хэрэгжүүлэх” цахим сургалт, Төрийн албан хаагчын ёс зүй сэдэвт сургалт, Нийслэлийн архивын газраас зохион байгуулсан цахим сургалт, Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт, шинжилгээ үнэлгээ сэдэвт цахим сургалтад тус тус албан хаагчдыг хамруулж ажиллаа.

- Төвийн багш, албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, зорилгоор “Багш хөгжил шавьд” лекц цуврал сургалтыг 3 удаа, дотоодын цахим сургалт 7 удаа, танхимын сургалт 1 удаа, хамтын ажиллагааны хүрээнд Монголын урлагийн зөвлөл болон бусад эрүүл мэндийн байгууллагатай хамтран мэргэжлийн болон эрүүл мэндийн сургалтуудыг зохион байгуулав. Туршлага солилцох цахим сургалтууд:

- Зураас уу? Зураг уу?” “ногоон алим” уран бүтээлийн тайлбар
- Үзэсгэлэн хэрхэн яаж гаргах тухай
- Урлагаар дамжуулан өөрийгөө хөгжүүлэх нь
- Хар зургийн үндэс уран зургийн тухай
- Байгаль судлал ба судалбар аялал бодит зургийн тухай
- Хуримтлал ба хадгаламж
- Эрүүл зөв хооллолт зэрэг цахим сургалтуудыг зохион байгууллаа.


Нийслэлийн Засаг Даргын хэрэгжүүлэгч агентлаг Архивын газраас зохион байгуулсан “Албан хэрэг хөтлөлтийн edoc системийн ашиглалт, ирсэн бичгийн шийдвэрлэлт “Архивийн хадгаламж бүрдүүлэх арга зүй” цахим сургалтад захиргааны 8 ажилтан хамрагдсан.





Хүний нөөцийн мэргэжилтэн Л.Атарын зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн” сургалтад 50 ажилтан албан хаагчид хамрагдсан.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Нийслэлийн прокурын газартай хамтран “Иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд прокурор төр, нийтийн ашиг сонирхолыг төлөөлөн хамгаалах нь” сургалтад төвийн Дэд захирал, Дотоод хяналт, хуулийн зөвлөх, Нийгмийн ажилтан, Архив бичиг хэргийн ажилтан нар хамрагдсан.



Албан хаагчид мэдлэг чадвараа дээшлүүлэх чиглэлээр:

№	Хамрагдсан сургалт	Сургалтанд хамрагдсан ажилчдын нэрс	Хугацаа
1	Монгол Улсын Боловсролын их сургуулийн боловсролын удирдлагын магистрын зэрэг олгох сургалт	Л.Атар – хүний нөөцийн ажилтан	2019-2022
2	МУИС-ийн Бизнесийн сургуульд Бизнес удирдлагын магистраар мэргэжил дээшлүүлэн суралцаж байна.	С.Ганцэцэг-Уран хатгамалын багш	2020-2021

3	Олон Улсын Улаанбаатар Их Сургуульд Бизнесийн удирдлагаар магистр – Төрийн албан хаагчийн тэтгэлэг	Б.Батчимэг-Захиралын туслах	2019-2021
4	Дүрслэх урлагийн академи – Уран зургийн чиглэлээр бакалавр зэрэг	Ц.Дуламсүрэн-Анхан шатны багш	2019-2023
5	ШУТИС –ийн харьяа ҮТСургуулийн Үйлдвэрлэлийн дизайнер Магистр зэрэг	Б.Ханхай-Барилгын макет, дизайны багш	2020-2022

3.5.2. Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах төлөвлөгөөг боловруулж биелэлтийг хангаж ажиллах

- Цалин хөлс, шагнал, урамшууллын чиглэлээр:

Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв, шатлал ахиулах нэмэгдлүүдийг ажлын үр дүнд үндэслэн олгож байна. Мөн багш, албан хаагчдад хоол унааны зардлыг тогтмол олгож байна.

Төвийн албан хаагчдаас улсад болон төрийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажилласан хамт олноо ажил үйлсээрээ манлайлж ажиллаж байгаа шилдэг, тэргүүний, ахмад багш, албан хаагчдыг төрийн дээд одон медаль, Засгийн газрын шагналд тодорхойлж шагнаж урамшуулсан.

Үүнд: Хүний нөөцийн мэргэжилтэн Л.Атар, Нярав Д.Оюунчимэг, Сүрлэн наамалын дугуйлангийн багш Р.Энхбаяр, лаборант С.Чимгээ нар Монгол Улсын төрийн дээд одон Алтангадас одонгоор, Нийгмийн ажилтан Б.Энхцэцэг, Уран зургийн багш М.Энхбаяр, Хүүхэлдэй бэлэг дусргалын багш А.Үржинханд нар төрийн дээд медаль Хөдөлмөрийн хүндэт медалиар, Уран зургийн багш Л.Баатардалай БШУЯамны шагнал “Боловсролын тэргүүний ажилтан” цол тэмдгээр тус тус шагнагдсан.

Багш, албан хаагчдын нийгмийн асуудалд анхаарч эрүүл мэндийг хамгаалах, спортын тэмцээн уралдааныг зохион байгуулах чиглэлээр:

- Томуу томуу төст өвчний тархалт болон шинэ “Коронавирус”-ийн халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг байгууллага дээрээ байнга хэрэгжүүлэн өрөө тасалгаанд ариун цэвэр халдваргүйжүүлэх хлорамин уусмалтай цэвэрлэгээ хийж, ариун цэврийн өрөөнд шингэн саван, спиртэд суурилсан гар ариутгагч тавин ажиллаж, албан хаагчдаа эрүүл мэндийн яамны мэдээллээр хангаж, халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж зөвлөгөөг тогтмол өгч ажиллаж байна.
- Ажилчдынхаа эрүүл мэндийг хамгаалах зорилгоор өдөр бүр биеийн халууныг хянаж байна.



- Ариутгал халдваргүйжүүлэлтийн хариу арга хэмжээний бэлэн байдлын нөөц хангалтыг нэмэгдүүлж ажилчдын гар угаах боломжийг бүрдүүлэн шингэн саван, белизна болон ариутгалын бодисоор байнга ханган ажиллаж байна.



- 0-12 насны хүүхэдтэй албан хаагчдыг цахимаар ажиллах боломжоор ханган ажиллуулж цалинг бүрэн олгосон.
- Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, дархлааг дэмжих, өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 3 төрлийн витаминаар улирал бүр хангаж ажилласан.



Багш, албан хаагчдын нийгмийн асуудалд анхаарч эрүүл мэндийг хамгаалах, спортын тэмцээн уралдааныг зохион байгуулах чиглэлээр:

Төвийн багш, албан хаагчдын эрүүл мэнд, хөдөлгөөний дутагдлыг арилгах зорилгоор өглөө бүр ажлын байрны дасгал хөдөлгөөн, гимнастик хийж, 14 хоногт нэг удаа спорт зааланд биеийн тамирын өдөрлөг зохион байгуулан ажиллаж байна.



Ажилчдынхаа эрүүл мэндийг хамгаалах, эрүүл ажлын байр ажлын хүрээнд “Эрүүл хоолны өдөрлөг”-ийг сар бүр 2 удаа зохион байгуулан ажиллаж байна. Ажилчид уг өдөрлөгийг зохион байгуулснаар эрүүл хооллолтын талаар мэдлэг хандлагатай болж байна.

Монголын Хүүхдийн Урлан бүтээх төвийн захиргаанаас санаачилан дэлхий нийтэд тархаад байгаа коронавируст халдвар цар тахалын үед байгууллагынхаа өрх толгойлсон албан хаагчид болон бага насны 2-оос дээш хүүхэдтэй 4 ажилтанд хүнсний болон ахуйн хэрэглээний тусламж үзүүлэх аяныг зохион байгуулсан. Үүнд: 10 кг гурил, 5 кг будаа, 5 литр ургамлын тос, 1кг чацаргана, 5 кг боорцог, 4 ш ариун цэврийн цаас, 1 гар ариутгагч, 10 ш маск, 5 уут түлшний мөнгийг нь гардуулан өгсөн. Мөн өрх бүрт гэр бүлийн бэлэг өгсөн.



Төвийн багш ажилчдыг ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх чиглэлээр байгууллагаас олгох зохих тэтгэмж, урамшууллыг хууль тогтоомжийн хүрээнд тухай бүр шийдвэрлэн ажиллаж байна.

Үүнд: 2021 оны 03,05 дугаар сард байгууллагаас тэтгэвэрт гарсан 2 ажилтаны шаардлагтай материалыг бүрдүүлэн өгч НЗДТГ-төрийн сангаас 2 ажилтанд 425586,4 сая төгрөгийн буцалтгүй тусламж өгсөн.

Хамт олны фондноос эмнэлэгт хэвтэх, хагалгаанд орох, хүүхэд төрүүлэх, гэр бүлийн хүмүүсээс нь нас барсан зэрэг гачигдал гарсан албан хаагчдад нийт 2,545,000 төгрөгний тусламж үзүүлж ажилласан.

ДУГНЭЛТ

Монголын Хүүхдийн Урлан Бүтээх төв нь 2021-2022 оны хичээлийн жилд “ӨВ СОЁЛОО ДЭЭДЭЛДЭГ БҮТЭЭЛЧ МОНГОЛ ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ” эрхэм зорилго дэвшүүлэн Монгол уран зураг, Монгол хувцас дизайны ангийг шинээр нээж 19 төрлийн 22 дугуйланд нийт 2200 хүүхдийг дүрслэх урлаг, гар урлал, техник технологийн чиглэлээр үнэ төлбөргүй сурган хөгжүүлж байна.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажилагааны хөтөлбөр, байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийг бүрэн хэрэгжүүлж, үйл ажиллагааны ил тод байдлыг ханган ажиллаж байна.

Байгууллагын батлагдсан төсвийг зүй зохистой зарцуулан, төсвийн хэмнэлт гаргаж өр төлбөргүй ажиллаа.

2021 онд Дэлхий нийтэд тархаад байгаа COVID19 шинэ төрлийн цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд гамшгаас хамгаалах Өндөржүүлсэн бэлэн байдлын болон Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан Засгын газар, Улсын Онцгой Комисс, Нийслэлийн Засаг даргын захирамж болон холбогдох тушаал, шийдвэрүүдийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаа.

ТАЙЛАНГ НЭГТГЭН ГАРГАСАН:

ХҮНИЙ НӨӨЦИЙН МЭРГЭЖИЛТЭН _____ /Л.АТАР/

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦАЖ, ЗӨВШӨӨРСӨН:

ЗАХИРАЛ _____ /Д.УРАНБИЛЭГ/